

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/11/НА-СТА-ТТЗ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p> | <p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас:51-261628 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn Аудитор: С.Болортуяа Утас:51-261628 Цахим хаяг: bolortuyas@audit.gov.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 2 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 7 |
| 2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан | 9 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 10 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд | 11 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 17 |
| 4.1 Ерөнхий зүйл | 21 |
| 4.2 Материаллаг байдал | 21 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 21 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 21 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 22 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 23 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 24 |
| 5.2.1. Албан шаардлага | 24 |
| 5.2 Зөвлөмж | 25 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 26 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| САГ | Санхүүгийн аудитын газар |
| СХЗГ | Стандарт, хэмжил зүйн газар |
| СХЗХ | Стандарт, хэмжил зүйн хэлтэс |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| УИХ | Улсын Их Хурал |
| УТХО | Улсын төсвийн хөрөнгө оруулалт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХАБҮЛЛ | Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| УТҮГ | Улсын төсвийн үйлдвэрийн газар |
| ТЭЗҮ | Техник эдийн засгийн үзүүлэлт |



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГА С.БАТБААТАР
ТАНАА

2026.03.25 № 796

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,239.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 283 дугаар тогтоол гарсан байхад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7,545.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасалт хийгээгүй, дансны үнийг шинэчлэн тогтоосон 5,134.7 сая төгрөгийн хөрөнгийг орлого авахдаа хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд буруу бүртгэж тайлагнасан;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,863.8 сая төгрөгийн барилгын их засварын ажлыг үндсэн хөрөнгийн дансанд капиталжуулж бүртгээгүй;
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын өр төлбөр өмнөх оноос 1,386.2 сая төгрөгөөр нэмэгдсэн.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжсэн 339.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Стандарт хэмжил зүйн газрын өргөтгөлийн барилгын зураг төслийг хүлээн авсан боловч үндсэн хөрөнгөнд бүртгээгүй.
- Биет бус хөрөнгөд бүртгэлтэй газар эзэмших эрхэд 43.3 сая төгрөгийн элэгдэл байгуулж, тайлагнасан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 72 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "оршин байх", "ангилал", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Стандарт, хэмжил зүйн газрын үндсэн үйл ажиллагааны орлогыг 9,855.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 20,350.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 10,495.2 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Үүнээс 10,175.3 сая төгрөгийг Сангийн яамтай тооцоо нийлж татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийт 11,934.2 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 11,399.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 21 төсөл, арга хэмжээг Төрийн худалдан авах ажиллагааны газраар, 534.6 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг байгууллагадаа тус тус зохион байгуулсан байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж 4,353.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 барилга, байгууламжийн их засвар хийлгэхээр, 6,128.7 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж худалдан авахаар хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт шалгалтын төлөвлөгөө", Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 134 дугаартай тушаалаар баталсан "Стандарт, хэмжил зүйн салбарын 2025 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт"-ыг үндэслэн батлагдсан удирдамжийн дагуу их, дунд эрсдэлтэй нийт 73 объектод хяналт шалгалтыг хийж, хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалттай холбоотой 598 гаруй зөрчил илрүүлж, 68 аж ахуйн нэгж байгууллагад зөрчил арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар бүхий улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж хэрэгжилтийг хангуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|--|----------------|------------------------|------------------------|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 3,687,602.1 | 12,673,668.4 |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 84,473.8 | 302,404.9 |
| АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 788,288.2 | 10,420,067.5 |
| УРЬДЧИЛГАА | 7а, 7б | 742,531.4 | - |
| БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 2,072,308.7 | 1,951,195.9 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 30,141,028.3 | 40,301,480.9 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 30,141,028.3 | 40,301,480.9 |
| Биет хөрөнгө | | 28,737,590.2 | 38,435,490.7 |
| Биет бус хөрөнгө | 13 | 1,403,438.1 | 1,865,990.1 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 33,828,630.4 | 52,975,149.3 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 76,595.2 | 1,462,780.0 |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 72,223.2 | 1,449,184.4 |
| Өглөг | 18а, 18б | 4,372.0 | 13,595.6 |
| Урьдчилж орсон орлого | | 33,752,035.2 | 51,512,369.2 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 33,752,035.2 | 51,512,369.2 |
| Засгийн газрын хувь оролцоо | | 9,474,838.1 | 9,365,998.4 |
| Засгийн газрын оруулсан капитал | | - | 109,019.7 |
| Хуримтлагдсан үр дүн | | 22,153,820.6 | 34,654,292.5 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 2,123,376.5 | 7,383,058.6 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 33,828,630.4 | 52,975,149.3 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|--|---------------|------------------------|------------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | 40,641,648.3 | 54,088,880.6 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 14,475,658.9 | 54,088,880.6 |
| Нийтлэг татварын бус орлого | | - | 31,435,614.5 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 26,165,989.4 | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 36,177,555.2 | 41,408,165.3 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | | 36,177,555.2 | 37,054,404.2 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 29,120,282.3 | 35,012,258.6 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 17,897,742.6 | 21,382,020.7 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 2,337,980.4 | 2,711,134.1 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 1,332,997.4 | 1,621,928.3 |
| Хангамж, бараа материалын зардал | | 664,006.0 | 671,350.7 |
| Норматив зардал | | 695,786.5 | 730,157.6 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | | 446,040.0 | 369,533.0 |
| Томилолт, зочны зардал | | 652,298.3 | 621,818.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 1,371,733.6 | 992,622.2 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 3,721,697.6 | 5,911,694.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 7,057,272.9 | 2,042,145.6 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 0.0 | 4,353,761.1 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 4,464,093.1 | 12,680,715.3 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | | 10,979.8 | 193,772.4 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | | (10,979.8) | (193,772.4) |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | | 4,453,113.3 | 12,486,942.9 |

2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|--|------------------------|------------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 40,719,227.8 | 52,007,225.7 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 12,287,514.7 | 52,007,225.7 |
| Нийтлэг татварын бус орлого | 12,287,514.7 | 20,714,206.7 |
| Тусламжийн орлого | - | 31,293,019.0 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 28,431,713.1 | - |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 36,733,510.6 | 41,163,975.3 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 36,733,510.6 | 41,163,975.3 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 27,360,348.4 | 28,891,500.0 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 17,998,388.9 | 21,376,852.1 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,258,520.8 | 2,716,831.2 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,534,6012.0 | 1,612,447.4 |
| Хангамж, бараа материалын зардал | 538,077.4 | 372,246. |
| Норматив зардал | 861,610.7 | 515,354.55 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 1,378,698.9 | 328,175.2 |
| Томилолт, зочны зардал | 657,595.1 | 466,578.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,387,599.0 | 1,125,571.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 745,255.6 | 377,443.8 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,373,162.2 | 12,272,475.3 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 3,985,717.1 | 10,843,250.4 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 3,938,916.4 | 10,625,319.2 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,938,916.4 | 10,625,319.2 |
| Дотоод эх үүсвэрээр | 3,938,916.4 | 10,625,319.2 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (3,938,916.4) | (10,625,319.2) |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 46,800.8 | 217,931.2 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 37,673.0 | 84,473.8 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 84,473.8 | 302,405.0 |

2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|--|--|-----------------------|------------------------|
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 29,299,237.5 | | 29,299,237.5 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (315.6) | | (315.6) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 29,298,921.5 | | 29,298,921.9 |
| Тайлант үеийн үр дүн | 4,453,113.3 | | 4,453,113.3 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 33,752,035.2 | | 33,752,035.2 |
| 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 33,752,035.2 | | 33,752,035.2 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 17,689.1 | | 17,689.1 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 33,769,724.4 | | 33,769,724.4 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 5,260,105.2 | | 5,260,105.2 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | (4,403.2) | | (4,403.2) |
| Тайлант үеийн үр дүн | 12,486,942.9 | | 12,486,942.9 |
| 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 51,512,369.2 | | 51,512,369.2 |

2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|---|-------------------|-------------------|---------------------|-------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 40,525,749,800.00 | 49,334,964,861.32 | (8,809,215,061.3) | 121.7 |
| 12 | Татварын бус орлого | 40,525,749,800.00 | 49,334,964,861.32 | (8,809,215,061.3) | 121.7 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 9,921,997,400.00 | 20,373,474,072.04 | (10,451,476,672.04) | 205.3 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 9,921,997,400.00 | 20,373,474,072.04 | (10,451,476,672.04) | 205.3 |
| 122 | Тусламжийн орлого | 30,603,752,400.00 | 28,961,490,789.28 | 1,642,261,610.72 | 94.6 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 30,603,752,400.00 | 28,961,490,789.28 | 1,642,261,610.72 | 94.6 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 40,525,749,800.00 | 39,134,934,643.76 | 1,390,815,156.24 | 96.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 30,042,549,800.00 | 28,652,422,377.16 | 1,390,127,422.84 | 95.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 29,266,604,400.00 | 27,902,594,750.04 | 1,364,009,649.96 | 95.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 20,691,458,500.00 | 20,530,743,256.37 | 160,715,243.63 | 99.2 |
| 210101 | Үндсэн цалин | 11,141,082,300.00 | 11,147,932,225.28 | (6,849,925.28) | 100.1 |
| 210102 | Нэмэгдэл | 5,054,222,300.00 | 4,995,921,686.24 | 58,300,613.76 | 98.8 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,517,403,600.00 | 2,594,787,004.57 | (77,383,404.57) | 103.1 |
| 210104 | Урамшуулал | 1,776,084,100.00 | 1,651,042,578.49 | 125,041,521.51 | 93.0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 202,666,200.00 | 141,059,761.79 | 61,606,438.21 | 69.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,635,619,400.00 | 2,613,117,414.20 | 22,501,985.80 | 99.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,806,901,600.00 | 1,787,970,268.56 | 18,931,331.44 | 99.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 207,221,700.00 | 205,655,386.06 | 1,566,313.94 | 99.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 103,691,700.00 | 117,159,997.89 | (13,468,297.89) | 113.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 103,559,800.00 | 100,447,865.75 | 3,111,934.25 | 97.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 414,244,600.00 | 401,883,895.94 | 12,360,704.06 | 97.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,679,517,300.00 | 1,581,182,274.61 | 98,335,025.39 | 94.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 285,415,600.00 | 291,193,654.91 | (5,778,054.91) | 102.0 |
| 210302 | Түлш, халаалт | 1,014,484,300.00 | 961,252,926.83 | 53,231,373.17 | 94.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 138,994,200.00 | 101,743,892.87 | 37,250,307.13 | 73.2 |
| 210304 | Байрны түрээс | 240,623,200.00 | 226,991,800.00 | 13,631,400.00 | 94.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 418,213,500.00 | 337,086,712.15 | 81,126,787.85 | 80.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 97,581,700.00 | 82,430,360.00 | 15,151,340.00 | 84.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 120,392,100.00 | 94,907,313.00 | 25,484,787.00 | 78.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 103,974,200.00 | 90,632,535.15 | 13,341,664.85 | 87.2 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 15,610,400.00 | 8,413,795.00 | 7,196,605.00 | 53.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 80,655,100.00 | 60,702,709.00 | 19,952,391.00 | 75.3 |
| 2105 | Норматив зардал | 673,408,100.00 | 513,721,648.00 | 159,686,452.00 | 76.3 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 564,323,400.00 | 449,882,600.00 | 114,440,800.00 | 79.7 |
| 210502 | Хоол, хүнс | 81,189,700.00 | 52,744,948.00 | 28,444,752.00 | 65.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 27,895,000.00 | 11,094,100.00 | 16,800,900.00 | 39.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 491,001,800.00 | 413,661,072.10 | 77,340,727.90 | 84.2 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 88,806,100.00 | 84,994,570.00 | 3,811,530.00 | 95.7 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 41,569,600.00 | 14,813,184.00 | 26,756,416.00 | 35.6 |
| 210604 | Урсгал засвар | 360,626,100.00 | 313,853,318.10 | 46,772,781.90 | 87.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 517,334,100.00 | 466,578,001.00 | 50,756,099.00 | 90.2 |
| 210701 | Гадаад албан томилолт | 72,178,700.00 | 63,425,320.00 | 8,753,380.00 | 87.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 442,365,400.00 | 401,852,681.00 | 40,512,719.00 | 90.8 |

Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|--------|---|-------------------|---------------------|---------------------|-------|
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 2,790,000.00 | 1,300,000.00 | 1,490,000.00 | 46.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,772,236,900.00 | 1,132,594,399.65 | 639,642,500.35 | 63.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,239,866,200.00 | 774,692,410.35 | 465,173,789.65 | 62.5 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 7,619,300.00 | 2,555,200.00 | 5,064,100.00 | 33.5 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,692,500.00 | 3,031,530.30 | 3,660,969.70 | 45.3 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4,314,100.00 | 2,215,004.00 | 2,099,096.00 | 51.3 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 775,800.00 | 278,900.00 | 496,900.00 | 35.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 378,304,200.00 | 237,377,989.00 | 140,926,211.00 | 62.7 |
| 210807 | Газрын төлбөр | 7,278,500.00 | 4,595,616.00 | 2,682,884.00 | 63.1 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 299,000.00 | 7,000.00 | 292,000.00 | 2.3 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 127,087,300.00 | 107,840,750.00 | 19,246,550.00 | 84.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 387,814,800.00 | 313,909,971.96 | 73,904,828.04 | 80.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 307,822,200.00 | 247,828,251.96 | 59,993,948.04 | 80.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 79,992,600.00 | 66,081,720.00 | 13,910,880.00 | 82.6 |
| 213 | ШИЛЖҮҮЛЭГ | 775,945,400.00 | 749,827,627.12 | 26,117,772.88 | 96.6 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 246,000,900.00 | 236,758,286.00 | 9,242,614.00 | 96.2 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 246,000,900.00 | 236,758,286.00 | 9,242,614.00 | 96.2 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 529,944,500.00 | 513,069,341.12 | 16,875,158.88 | 96.8 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,320,000.00 | 2,320,000.00 | - | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 490,478,800.00 | 487,726,309.32 | 2,752,490.68 | 99.4 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 29,623,700.00 | 15,501,031.80 | 14,122,668.20 | 52.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,522,000.00 | 7,522,000.00 | - | 100.0 |
| 22 | ЗАРДАЛ | 10,483,200,000.00 | 10,482,512,266.60 | 687,733.40 | 100.0 |
| 221001 | Их засвар | 4,354,400,000.00 | 4,353,761,136.60 | 638,863.40 | 100.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 6,128,800,000.00 | 6,128,751,130.00 | 48,870.00 | 100.0 |
| 8 | ТЭНЦЭЛ | - | 10,200,030,217.56 | (10,200,030,217.56) | 100.0 |
| 9 | ҮҮСВЭР | - | (10,200,030,217.56) | 10,200,030,217.56 | 100.0 |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - | (10,200,030,217.56) | 10,200,030,217.56 | 100.0 |
| 61 | ТОО | 23 | 20 | 3 | 87.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 23 | 20 | 3 | 87.0 |
| 62 | ТОО | 644 | 603 | 41 | 93.6 |
| 620001 | Удирдах ажилтан | 33 | 30 | 3 | 90.9 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 502 | 413 | 89 | 82.3 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 109 | 160 | (51) | 146.8 |
| 65 | МЭДЭЭЛЭЛ | 644 | 399 | 245 | 62.0 |
| 650001 | ТЗ | 224 | 211 | 13 | 94.2 |
| 650007 | ТҮМБ | - | 12 | (12) | 100.0 |
| 650009 | ТҮ | 126 | 176 | (50) | 139.7 |
| 650014 | ТҮМ | 294 | - | 294 | - |

| | | | | | |
|--------|--|----|----|---|------|
| 66 | ГАРАГЧ | 20 | 17 | 3 | 85.0 |
| 660001 | Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч | 20 | 17 | 3 | 85.0 |

2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|--------|---|------------------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,192,142,074.59 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,192,142,074.59 |
| 122 | Тусламжийн орлого | 1,192,142,074.59 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 1,192,142,074.59 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,192,142,074.59 |
| 350011 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 14,468,750.00 |
| 350013 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 726,390,689.20 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 252,504,015.62 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 198,778,619.77 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,148,343,875.50 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,148,343,875.50 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,120,843,875.50 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 856,108,887.03 |
| 210101 | Үндсэн цалин | 69,392,855.16 |
| 210102 | Нэмэгдэл | 670,537,183.77 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,905,661.10 |
| 210104 | Урамшуулал | 104,673,187.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,600,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 103,713,816.81 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 75,252,132.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,563,256.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,274,026.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,238,263.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,386,137.21 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,265,121.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,715,121.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,293,408.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,275,080.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,520,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 189,728.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,308,400.00 |
| 2105 | Норматив зардал | 9,033,150.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,337,030.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3,696,120.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 29,858,942.66 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 29,858,942.66 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,195,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,195,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 47,375,550.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,842,177.02 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,533,372.98 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 27,500,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 27,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 27,500,000.00 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 43,798,199.09 |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (43,798,199.09) |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (43,798,199.09) |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Стандарт, хэмжил зүйн газар эрхэм зорилгоо “Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

СХЗГ нь стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдэл байдлыг хангах, баталгаажуулалтын түвшнийг дээшлүүлэн, олон улсын жишигт хүргэж хөгжүүлэх, итгэмжлэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах зэрэг үйл ажиллагааг эрхэлдэг Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага юм.

Тайлант үеийн онцлог үйл явдлууд:

- Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, чиглэлээр 2025 оны 05 дугаар сард 2025-2026 онд хэрэгжих Олон улсын стандартын байгууллага (ISO) болон Германы физик техникийн хүрээлэн (РТВ)-ийн хамтарсан “Тойрог эдийн засгийн бүлэг стандартуудыг нэвтрүүлэх төсөл”-д санал хүргүүлж дэмжигдсэн;
- Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 71 дүгээр тушаалаар “Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” журмыг батлуулсан;
- Хэмжил зүйн болон сорилтын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, эталоны баазыг хөгжүүлэх чиглэлээр 5.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүйн үзүүлэлтийн шинжилгээний суурь нөхцөл хангагдсан. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн чадавхыг 10 хувиар нэмэгдүүлсэн;
- “Бүтээгдэхүүн, үйлчилгээ, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын нэгдсэн сан” системийг 2025 онд нэвтрүүлж, цахим системээр нийт 7 үйлчилгээг (www.cert.masm.gov.mn) сайтаар дамжуулан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд цахимаар авах боломжтой болсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

СХЗГ нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт оржээ. Тухайлбал:

- Сангийн сайдын 2025 оны “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” А/03 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2025 оны “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай” А/103-106 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2025 оны “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” 240 дүгээр тушаал.

Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаатай холбоотой дараах дүрэм, журмын төслийг тайлант онд шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулсан байна. Тухайлбал:

- Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 71 дүгээр тушаалаар “Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан;
- Хэмжил зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 250 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж батлуулсан;

- СХЗГ-ын 1 дүгээр байрны Их засварын үед мөрдөх түр журмын төсөл боловсруулж, холбогдох нэгжийн дарга нараас санал авч, хянуулан Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/138 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс мөрдөн ажиллаж байгаа;
- СХЗГ-ын даргын Зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар “Хэмжих хэрэгслийн загварыг турших журам”, “Хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийх журам”-ыг шинэчлэн батлуулахаар хянасан. Мөн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн шийдвэрээр дээрх журмуудыг шинэчлэн батлуулах, холбогдох байгууллагуудад бүртгүүлэхээр шийдвэрлэсэн;
- “Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын төслийг боловсруулж, батлуулахаар зохион байгуулалтын нэгжийн дарга нараас саналыг авч нэгтгэн даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ханган ажилласан байна.

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 10 дүгээр сарын 31-ний өдрийн А/296 дугаар тушаал, удирдамжаар аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлэн, илэрсэн алдаа зөрчилд зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

СХЗГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2024 онд баталсан бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбогдох стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлтийг тусгаагүй, бэлэн бүтээгдэхүүний дансанд үнэт цааснуудыг, бусад үндсэн хөрөнгийн бүртгэлд сорьцын баталгаажуулалтын хэрэгсэл буюу бараа материалын шинж чанартай зүйлсийг бүртгэдэг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

СХЗГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны А/341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 52,975.1 сая төгрөг болж өмнөх оноос 19,146.5 сая төгрөгөөр буюу 56.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|---------------------|---------------------|---------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 84,473.8 | 302,405.0 | 217,931.2 |
| Авлага | 788,288.3 | 10,420,067.5 | 9,631,779.2 |
| Урьдчилгаа | 742,531.4 | | (742,531.4) |
| Бараа материал | 2,072,308.7 | 1,951,195.9 | (121,112.8) |
| Үндсэн хөрөнгө | 30,141,028.3 | 40,301,480.9 | 10,160,452.6 |
| Нийт хөрөнгө | 33,828,630.5 | 52,975,149.3 | 19,146,518.8 |
| Өглөг | 72,223.2 | 1,449,184.4 | 1,376,961.2 |
| Урьдчилж орсон орлого | 4,372.0 | 13,595.7 | 9,223.7 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 33,752,035.2 | 51,512,369.2 | 17,760,334.0 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 33,828,630.4 | 52,975,149.3 | 19,146,518.9 |

Эх сурвалж: СХЗГ 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, урьдчилж орсон орлого, засгийн газрын хувь оролцоо данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 302.4 сая төгрөг болж, өмнөх оноос 217.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------|-----------------|------------------|---------------------------|
| Банканд байгаа бэлэн мөнгө | 84,473.8 | 302,405.0 | 217,931.2 |
| Төрийн сангийн харилцах | 84,473.8 | 302,405.0 | 217,931.2 |
| Дүн | 84,473.8 | 302,405.0 | 217,931.2 |

Эх сурвалж: СХЗГ 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сан банкин дахь мөнгөн хөрөнгийн 302.4 сая төгрөгийн үлдэгдэл нь барьцаа дансны хөрөнгийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: СХЗГ-ын харьяа байгууллагуудад мөнгөн хөрөнгийн дансны зарцуулалтай холбоотой нийт 148.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Хэвлэл мэдээллийн зардалд олон нийтэд таниулах, сурталчлах зардлыг санхүүжүүлсэн 102.8 сая төгрөг; /Хэнтий аймаг дахь СХЗХ 10.5 сая төгрөг, Төв аймаг дахь СХЗХ 10.5 сая төгрөг, Ховд аймаг дахь СХЗХ 10.0 сая төгрөг, Завхан аймаг дахь СХЗХ 10 сая төгрөг, Дундговь аймаг дахь СХЗХ 9.8 сая төгрөг, Баянхонгор аймаг дахь СХЗХ 9.8 сая төгрөг, Дорнод аймаг дахь СХЗХ 7.8 сая төгрөг, Өмнөговь аймаг дахь СХЗХ 7.0 сая төгрөг, Орхон аймаг дахь СХЗХ 7.0 сая төгрөг, Хөвсгөл аймаг дахь СХЗХ 7 сая төгрөг, Дорноговь аймаг дахь СХЗХ 3.0 сая төгрөг/
- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү тооцож олгосон, нийгмийн даатгалын шимтгэл, татварыг зөрүүтэй суутгасан 36.7 сая төгрөг; /ХАБҮЛЛ 9.4 сая төгрөг, Увс аймаг дахь СХЗХ 6.5 сая төгрөг, Хөвсгөл аймаг дахь СХЗХ 4.9 сая төгрөг Говь-алтай аймаг дахь СХЗХ 4.8 сая төгрөг, Орхон аймаг дахь СХЗХ 4.2 сая төгрөг, Завхан аймаг дахь СХЗХ 2.2 сая төгрөг, Дорнод аймаг дахь СХЗХ 2.0 сая төгрөг, Дорноговь аймаг дахь СХЗХ 1.4 сая төгрөг, Төв аймаг дахь СХЗХ 0.9 сая төгрөг, Хэнтий аймаг дахь СХЗХ 0.3 сая төгрөг, Дархан-Уул аймаг дахь СХЗХ 0.1 сая төгрөг/
- Түлш халаалтын зардлаас 1.8 сая төгрөгийг үндэслэлгүйгээр илүү олгосон; /Архангай аймаг дахь СХЗХ/
- Булган аймаг дахь СХЗХ нь тайлант онд ахмадын сангийн хөрөнгөөс 2 ахмадад гадаад улс руу эмчилгээнд явахад 7.0 сая төгрөгийг хорооны шийдвэргүй зарцуулсан;
- Дорнод аймаг дахь СХЗХ нь анхан шатны баримтуудыг гарын үсгээр баталгаажуулаагүй.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 10,420.1 сая төгрөг болж, өмнөх оноос 9,631.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-------------------------------|------------------|---------------------|---------------------------|
| Ажиллагчтай холбогдсон авлага | 6,638.3 | 11,124.2 | 4,485.9 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 695,209.9 | 86,919.9 | (608,290.0) |
| Татаас санхүүжилтийн авлага | 13,902.0 | 10,236,972.3 | 10,223,070.3 |
| Байгууллагаас авах авлага | 46,757.2 | 59,660.2 | 12,903.0 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 25,780.9 | 25,390.9 | (390.0) |
| Дүн | 788,288.3 | 10,420,067.5 | 9,631,779.2 |

Эх сурвалж: СХЗГ 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдлийн 0.1 хувийг ажиллагчтай холбогдсон авлага, 0.8 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага, 98.2 хувийг татаас санхүүжилтийн авлага, 2.2 хувийг байгууллагаас авах авлага, 0.2 хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна.

Авлагын дансны үлдэгдэл 9,631.8 сая төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага 10,062.6 сая төгрөгөөр, ажиллагчтай холбогдсон авлага 4.5 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 4.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Татаас санхүүжилтийн авлага нь Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагыг хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны давсан орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, ханалт тавих журам”-ын дагуу 2025 оны нэмэлт давсан орлогын дүнгээр өссөн байна.

Аудитын илрүүлэлт: СХЗГ-ын харьяа байгууллагуудад авлагын данстай холбоотой нийт 96.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- СХЗГ-ын үндсэн үйл ажиллагааны орлогын нийт 72.7 сая төгрөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй, тайлант оны эцэст авлагатай гарсан;
- ХАБҮЛЛ нь харилцагч байгууллагуудаас авах нийт 19.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Говьсүмбэр аймаг дахь СХЗХ нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 4.5 сая төгрөгийн ХХОАТ, НДШ-ийн авлага тайлагнасан.

3.4.3 Урьдчилгаа

Тайлант онд Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэлгүй гарсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------|------------------|-----------------|---------------------------|
| Урьдчилж гарсан зардал | 742,531.4 | - | (742,531.4) |
| Дүн | 742,531.4 | - | (742,531.4) |

Эх сурвалж: СХЗГ 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй болсон нь өмнөх онд бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудад урьдчилж төлсөн 742.5 сая төгрөгийн гэрээг дүгнэж, хөрөнгийг хүлээн авсантай холбоотой.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,951.2 сая төгрөг болж, өмнөх оноос 121.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|--------------------|----------------|-----------------|---------------------------|
| Түүхий эд материал | 595,275.5 | 500,612.2 | (94,663.3) |

| | | | |
|------------------------------|--------------------|--------------------|--------------------|
| Тусгай зориулалттай материал | 146,502.2 | 146,133.0 | (369.2) |
| Эм боох материал | 448,773.3 | 354,479.2 | (94,294.1) |
| Бэлэн бүтээгдэхүүн | 64,645.2 | 57,106.8 | (7,538.4) |
| Хангамжийн материал | 1,412,388.0 | 1,393,476.9 | (18,911.1) |
| Бичиг хэргийн материал | 81,286.1 | 81,688.9 | 402.8 |
| Аж ахуйн материал | 318,642.3 | 306,164.7 | (12,477.6) |
| Сэлбэг хэрэгсэл | 42,125.7 | 32,123.0 | (10,002.7) |
| Түлш, шатах тослох материал | 13,133.4 | 12,101.9 | (1,031.5) |
| Барилгын засварын материал | 37,430.4 | 33,996.9 | (3,433.5) |
| Хүнсний материал | 60,591.7 | 26,725.9 | (33,865.8) |
| Бусад хангамжийн материал | 859,178.4 | 900,675.6 | 41,497.2 |
| Дүн | 2,072,308.7 | 1,951,195.9 | (121,112.8) |

Эх сурвалж: СХЗГ 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 71.4 хувийг хангамжийн материал, 25.7 хувийг түүхий эд материал, 2.9 хувийг бэлэн бүтээгдэхүүн эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4,308.7 сая төгрөгийн, хандив тусламжаар 12.7 сая төгрөгийн, үнэ төлбөргүй шилжүүлж авсан 214.6 сая төгрөгийн, нийт 4,536.0 сая төгрөгөөр бараа материал нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 1,663.6 сая төгрөгийн, балансаас баланст шилжүүлсэн 2,933.5 сая төгрөгийн, данс хооронд болон акталсан 60.0 сая төгрөгийн, нийт 4,657.1 сая төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Бараа материалын үлдэгдэл буурахад эм боох материал 94.3 сая төгрөгөөр, хүнсний материал 33.9 сая төгрөгөөр, аж ахуйн материал 12.5 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 10.0 сая төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүн 7.5 сая төгрөгөөр, түлш шатах тослох материал 1.0 сая төгрөгөөр, барилгын засварын материал 3.4 сая төгрөгөөр, тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт: СХЗГ-ын харьяа байгууллагуудад бараа материалын данстай холбоотой нийт 98.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- ХАБҮЛЛ нь бараа материалын бүртгэлд оны эхнээс огт хөдөлгөөн ороогүй 281 нэр төрлийн 643 ширхэг эм урвалжийн материал 59.7 сая төгрөгийн нөөцтэй;
- Хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, жилийн эцсийн тооллогын бүртгэл бараа материалын тайлангаас 17.8 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан; /СХЗГ/
- Баянхонгор аймаг дахь СХЗХ нь бараа материалын дансанд сорил гүйцэтгэхэд эд хариуцагчийн тайлан санхүүгийн тайлангаас 11.1 сая төгрөгийн зөрүүтэй буюу зарим дүнг давхардуулан илэрхийлсэн, эргэлтийн хөрөнгийн тооллогын тайланг гаргаж тооцоо бодоогүй;
- Өмнөговь аймаг дахь СХЗХ нь бараа материалын орлого, зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад зарлагын 7.6 сая төгрөгийн дүн бүхий 64 гүйлгээний шаардах хуудасны гарын үсэг тамгаар баталгаажуулаагүй, шаардах хуудсыг иж бүрэн бөглөөгүй;
- Увс аймаг дахь СХЗХ нь 1.5 сая төгрөгийн 580 литр шатах тослох материалыг гарын үсгийн бүрдэл дутуу баримтаар зарцуулсан;
- Төв аймаг дахь СХЗХ нь түлш, шатах тослох материалын 1.1 сая төгрөгийн нөөц бүрдүүлсэн.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 40,301.5 сая төгрөг болж, өмнөх оноос 10,160.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------------|---------------------|---------------------|---------------------------|
| Биет хөрөнгө | 28,737,590.1 | 38,435,490.7 | 9,697,900.6 |
| Барилга, байгууламж, орон сууц | 17,985,832.5 | 18,792,776.2 | 806,943.7 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 737,445.4 | 963,944.8 | 226,499.4 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 8,038,307.1 | 15,299,267.3 | 7,260,960.2 |

| | | | |
|-------------------------------|---------------------|---------------------|--------------|
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 688,630.4 | 1,693,490.7 | 1,004,860.3 |
| Зам, гүүрний байгууламж | 2,391.7 | 606,880.7 | 604,489.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 1,248,426.6 | 1,072,574.6 | (175,852.0) |
| Дуусаагүй барилга, байгууламж | 30,000.0 | - | (30,000.0) |
| Номын фонд | 6,556.4 | 6,556.4 | - |
| Биет бус хөрөнгө | 1,403,438.2 | 1,865,990.2 | 462,552.0 |
| Программ хангамж | 207,518.1 | 435,727.0 | 228,208.9 |
| Бусад биет бус хөрөнгө | 1,195,920.1 | 1,430,263.2 | 234,343.1 |
| Дүн | 30,141,028.3 | 40,301,480.9 | 10,160,452.6 |

Эх сурвалж: СХЗГ 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгийн 46.6 хувийг барилга, байгууламж, 2.4 хувийг тээврийн хэрэгсэл, 4.6 хувийг биет бус хөрөнгө, 39.5 хувийг тоног төхөөрөмж, 4.2 хувийг тавилга, эд хогшил, 2.7 хувийг бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 3,642.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандиваар 255.1 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 6,867.1 сая төгрөгийн, хөрөнгийн үнийг шинэчлэн 5,906.7 сая төгрөгөөр тогтоосон, нийт 16,671.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж 493.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 1,588.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 1,733.6 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж нийт 3,815.2 сая төгрөгийн хөрөнгийг зарлагдсан.

Тайлант хугацаанд хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл 2,695.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Аудитын илрүүлэлт: СХЗГ-ын харьяа байгууллагуудад үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 16,555.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,863.8 сая төгрөгийн барилгын их засварын ажлыг хөрөнгийг капиталжуулж бүртгээгүй, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, жилийн эцсийн тооллогын бүртгэл, илтгэх хуудаст тусгасан программ хангамжийн дүнг 289.0 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан; /СХЗГ/
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 292.9 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлэх арга хэмжээ аваагүй; /ХАБҮЛЛ/
- ТӨБЗГ-ын 2025 оны 283 дугаар тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7,545.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаагүй, дансны үнийг шинэчлэн тогтоосон 5,134.7 сая төгрөгийн хөрөнгийг орлого авахдаа дансанд буруу бүртгэсэн, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хийгдсэн их засварын ажлыг капиталжуулахдаа 282.7 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн, 56.6 сая төгрөгийн хөрөнгөнд элэгдлийн зардлыг тооцоогүй; /ХАБҮЛЛ/
- Хөвсгөл аймаг дахь СХЗХ нь биет бус хөрөнгийн дансанд 1026.3м.кв, 1100м.кв нийт 2126 м.кв талбайтай 2 хэсэг 53.1 сая төгрөгийн өртөгтэй газар бүртгэлтэй байх боловч улсын цахим бүртгэлийн нэгдсэн системд 1198м.кв талбайтай 29.9 сая төгрөгийн өртөгтэй газар эзэмших эрх бүртгэлтэй. Санхүүгийн тайланд 928 м.кв талбай буюу 23.2 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан;
- Дундговь аймаг дахь СХЗХ нь элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой 13.9 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэ шинэчлэн тогтоогүй;
- Төв аймаг дахь СХЗХ-ийн дансанд бүртгэлтэй 8564 ТӨА улсын дугаартай тээврийн хэрэгсэлд 0.5 сая төгрөгийн торгууль ногдуулсан;
- Хэнтий аймаг дахь СХЗХ нь үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийн дахин үнэ шинэчлэн тогтоогоогүй.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,449.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1,366.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------------------|-----------------|------------------|------------------------|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 20,764.8 | 107,339.0 | 86,574.2 |

| | | | |
|---|-----------------|--------------------|--------------------|
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,792.9 | 84,071.4 | 81,278.5 |
| Бусад өглөг | 48,665.5 | 1,257,774.0 | 1,209,108.5 |
| Байгууллагад төлөх өглөг | 30,465.3 | 1,182,920.8 | 1,152,455.5 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 18,200.2 | 74,853.2 | 56,653.0 |
| Дүн | 72,223.2 | 1,449,184.4 | 1,376,961.2 |

Эх сурвалж: СХЗГ 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдлийн 7.4 хувийг ажилчидтай холбоотой, 5.8 хувь нь бараа үйлчилгээний зардалтай, 86.7 хувь нь байгууллага, хувь хүмүүстэй холбоотой өглөг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: СХЗГ-ын харьяа байгууллагуудад өр төлбөрийн данстай холбоотой нийт 198.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- ХАБҮЛЛ нь харилцагч байгууллагад өгөх өрийн 89.8 сая төгрөгийн үлдэгдэлд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Увс аймаг дахь СХЗХ нь байгууллагын тодотгосон төсвийг 51.5 сая төгрөгөөр хэтрүүлэн өр төлбөр үүсгэн санхүүгийн тайланд тусгасан;
- Батлагдсан төсвөөс хэтрүүлэн албан хаагчдад гадаад албан томилолтын зардалд 21.1 сая төгрөг, Олон улсын чуулга уулзалтын бүртгэлийн хураамж 10.4 сая төгрөг, дотоод албан томилолтын зардалд 3.3 сая төгрөг, нийт 34.9 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, 3.4 сая төгрөгийн байгууллагатай холбогдсон өр төлбөр үүсгэсэн; /СХЗГ/
- Говьсүмбэр аймаг дахь СХЗХ нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 2.3 сая төгрөгийн бараа үйлчилгээний зардлын өр төлбөр тайлагнасан.

3.4.8 Урьдчилж орсон орлого

Нийт урьдчилж орсон орлого дансны эцсийн үлдэгдэл 13.6 сая төгрөг болж, өмнөх оноос 9.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Урьдчилж орсон орлогын үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ | |
|-----------------------------|----------------|--------------------|------------------------|
| | | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Урьдчилж орсон орлого | 4,372.0 | 13,595.7 | 9,223.7 |
| Бусад урьдчилж орсон орлого | 4,372.0 | 13,595.7 | 9,223.7 |
| Дүн | 4,372.0 | 13,595.7 | 9,223.7 |

Эх сурвалж: СХЗГ 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж төлсөн орлого нэмэгдсэн нь СХЗГ-т 9.2 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого урьдчилж төлөгдсөнтэй холбоотой.

3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 51,512.4 сая төгрөг болж, өмнөх оноос 17,760.3 сая төгрөгөөр өссөн.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ | |
|--|---------------------|---------------------|------------------------|
| | | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 9,474,838.1 | 9,475,018.1 | 180.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 22,153,820.6 | 34,654,292.5 | 12,500,471.9 |
| Өмнөх үеийн үр дүн | 17,700,707.3 | 22,167,349.6 | 4,466,642.3 |
| Тайлант үеийн үр дүн | 4,453,113.3 | 12,486,942.9 | 8,033,829.6 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,123,376.5 | 7,383,058.6 | 5,259,682.1 |
| Дүн | 33,752,035.2 | 51,512,369.2 | 17,760,334.0 |

Эх сурвалж: СХЗГ 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс өсөхөд 12,486.9 сая төгрөгийн тайлант үеийн үр дүн голлон нөлөөлсөн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

СХЗГ-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2025 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 39,843.0 сая төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжилтээс 30,228.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 9,601.1 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 13.3 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардал 7,588.5 сая төгрөгөөр буурч, 32,254.5 сая төгрөгөөр батлагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг 78,211.7 сая төгрөгөөр төсөвлөн явуулснаас 11,399.6 сая төгрөг батлагдсан.

2025 онд салбарын хэмжээнд 69 албан хаагчийг цомхотгох шийдвэр гарч, цалин болон НДШ-ийн зардлаас 1,163.9 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний зардлаас 935.0 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлаас 113.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлаас 916.4 сая төгрөгийн зардлыг тус тус хассан байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 42 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч Стандарт, хэмжил зүйн салбарын 2025 оны хагас жил болон жилийн эцэст өргүй тайлагнах үүднээс нийт 5 удаа, 1,263.7 сая төгрөгийн зардлыг зардал хооронд гүйлгэн шилжүүлэх зохицуулалтуудыг хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны 19,627.3 сая төгрөг, хөрөнгийн 10,483.0 сая төгрөгийн, нийт 41,458.5 сая төгрөгийн санхүүжилт авч 1,156.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд гүйцэтгэлээр 20,373.5 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар 10,175.3 сая төгрөгийн давсан орлогыг зарцуулах эрх олгон үндсэн данснаас нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн.

Үндсэн үйл ажиллагааны 9,922.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас орлогын гүйцэтгэлээр 20,373.5 сая төгрөгийг тайлагнаснаар, төлөвлөгөөг 10,451.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 10. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

| Байгууллагын нэр | Орлогын төлөвлөгөө | Орлогын гүйцэтгэл | / мянган төгрөгөөр/ |
|------------------|--------------------|-------------------|----------------------------|
| | | | Зөрүү /давсан-, тасарсан+/ |
| Архангай СХЗХ | 70,000.0 | 182,524.1 | (112,524.1) |
| Баян-Өлгий СХЗХ | 60,000.0 | 208,010.3 | (148,010.3) |
| Баянхонгор СХЗХ | 565,000.0 | 946,841.3 | (381,841.3) |
| Булган СХЗХ | 60,000.0 | 98,266.8 | (38,266.8) |
| Говь-Алтай СХЗХ | 60,000.0 | 123,637.6 | (63,637.6) |
| Дорноговь СХЗХ | 135,000.0 | 198,403.5 | (63,403.5) |
| Дорнод СХЗХ | 150,000.0 | 412,116.9 | (262,116.9) |
| Дундговь СХЗХ | 65,000.0 | 106,501.6 | (41,501.6) |
| Завхан СХЗХ | 70,000.0 | 139,444.0 | (69,444.0) |
| Өвөрхангай СХЗХ | 80,000.0 | 151,134.4 | (71,134.4) |

| | | | |
|-----------------------------|--------------------|---------------------|-----------------------|
| Өмнөговь СХЗХ | 350,000.0 | 1,196,523.3 | (846,523.3) |
| Сүхбаатар СХЗХ | 70,000.0 | 122,983.5 | (52,983.5) |
| Сэлэнгэ СХЗХ | 200,000.0 | 457,533.9 | (257,533.9) |
| Төв СХЗХ | 105,000.0 | 451,435.6 | (346,435.6) |
| Увс СХЗХ | 120,000.0 | 201,246.4 | (81,246.4) |
| Ховд СХЗХ | 90,000.0 | 191,041.0 | (101,041.0) |
| Хөвсгөл СХЗХ | 130,000.0 | 238,481.5 | (108,481.5) |
| Хэнтий СХЗХ | 70,000.0 | 182,013.6 | (112,013.6) |
| Дархан-Уул СХЗХ | 565,000.0 | 1,496,275.6 | (931,275.6) |
| Орхон СХЗХ | 160,000.0 | 533,343.4 | (373,343.4) |
| Говьсүмбэр СХЗХ | 20,000.0 | 66,560.6 | (46,560.6) |
| Стандарт, хэмжил зүйн газар | 5,226,997.4 | 10,954,474.8 | (5,727,477.4) |
| ХАБҮЛЛ | 1,500,000.0 | 1,714,680.4 | (214,680.4) |
| Дүн | 9,921,997.4 | 20,373,474.1 | (10,451,476.7) |

Аудитын илрүүлэлт: СХЗГ-ын харьяа байгууллагуудад орлогын данстай холбоотой нийт 411.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг "Дижитал медик" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулаагүйгээр мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээний хураамжийн нийт 228.5 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг тус аж ахуйн нэгжийн дансаар дамжуулан байгууллагын дансанд төвлөрүүлсэн нь үндсэн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байх, байгууллага хооронд үүсэх харилцаа, маргааныг зохицуулах боломжгүй үр дагавартай; /СХЗГ/
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогын дүн нь сорьцын шинжилгээний "Лимис" программын орлогын дүнгээс 182.8 сая төгрөгөөр илүү тусгагдсан. /ХАБҮЛЛ/

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хэмжээг санхүүжүүлэхээр 40,525.7 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээс гүйцэтгэлээр улсын төсвөөс 28,961.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 20,373.4 сая төгрөг, нийт 49,334.8 мянган төгрөгийн орлогын бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 39,134.9 сая төгрөгийг зарцуулж, 10,199.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 39,134.9 сая төгрөг буюу 96.6 хувьтай байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 929.7 сая төгрөгөөр, мэдээлэл сурталчилгааны зардлыг 32.2 сая төгрөгөөр, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлыг 220.1 сая төгрөгөөр, харуул хамгаалалтын зардлыг 68.8 сая төгрөгөөр, зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардлыг 68.8 сая төгрөгөөр, лабораторийн итгэмжлэлийг 44.4 сая төгрөгөөр, гишүүнчлэлийн хураамжийг 26.1 сая төгрөгөөр, бусад ангиллын зардлыг 0.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт /хувь/ |
|--------------|----------------------------------|---------------------|---------------------|--------------------|----------------|
| 70407 | Стандартчилал, хэмжил зүй | 40,525,749.8 | 39,134,934.6 | 1,390,815.2 | 96.6 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 28,051,024.9 | 27,121,307.4 | 929,717.5 | 96.7 |
| 80205 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 230,443.5 | 198,242.5 | 32,201.0 | 86.0 |
| 80215 | Эрдэм шинжилгээ, судалгааны ажил | 294,763.3 | 74,712.2 | 220,051.1 | 25.3 |
| 80219 | Харуул хамгаалалтын зардал | 544,407.6 | 475,597.1 | 68,810.5 | 87.4 |

| | | | | | |
|-------|---|--------------|--------------|----------|-------|
| 80224 | Зөвлөл, хороо, комиссын гишүүд | 79,365.1 | 10,535.7 | 68,829.4 | 13.3 |
| 80227 | Лабораторийн итгэмжлэл | 66,600.0 | 22,200.0 | 44,400.0 | 33.3 |
| 80509 | Гадаадын болон олон байгууллагын гишүүнчлэл хураамж | 246,000.9 | 236,758.2 | 9,242.7 | 96.2 |
| 80802 | Улсын гишүүнчлэлийн хураамж | 529,944.5 | 513,069.3 | 16,875.2 | 96.8 |
| 80918 | Бусад | 10,483,200.0 | 10,482,512.2 | 687.8 | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар СХЗГ орон тооны хязгаарыг 713 орон тоогоор баталсныг 9 хувиар буюу 60 орон тоогоор бууруулж 653 байхаар баталжээ. Үүний дагуу Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 10 дугаар сарын 08-ний өдрийн 158 даргын 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/188 тоот тушаалаар байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн баталсан байна.
- СХЗГ-ын харьяа байгууллагын тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд 2,517.4 сая төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 2,594,8 сая төгрөгийг зарцуулж, 77.4 сая төгрөгийг хэтрүүлсэн нь унаа хоолны мөнгө нэмэгдүүлсэнтэй холбоотой;
- Гадаад зочин хүлээн авах арга хэмжээний зардалд 2.8 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 1.3 сая төгрөг зарцуулсан. Гадаад томилолтын зардалд 72.2 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 63.4 сая төгрөгийг олон улсын гишүүнчлэлийн сургалт семинарын зардалд зарцуулсан байна. Гадаад томилолтын 24.5 сая төгрөгийн өглөг тайлагнасан нь зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хянаж зарцуулахгүй байгааг харуулж байна.
- Тайлант хугацаанд хичээл, үйлдвэрлэлийн зардалд 80.0 сая төгрөгийг төсөвлөж, гүйцэтгэлээр 66.1 сая төгрөгийг зарцуулсан. Стандарт ба эрх зүйн орчин сургалт, семинарын зардалд 40.6 сая төгрөг, төр, хувийн хэвшил мэргэжлийн холбоодын дунд стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчны хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн хэлэлцүүлэг 1.7 сая төгрөг, удирдах ажилтны зөвлөгөөнд 12.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Стандартчиллыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэх ажлын хүрээнд 18 хуулийн этгээдтэй 231.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 189.2 сая төгрөгийг санхүүжүүлж үлдэгдэл 42.0 сая төгрөгийн өртэй байна;
- СХЗГ-ын харьяа байгууллагаас төрд учирсан хохирлыг барагдуулах зардалд 15.0 сая төгрөгийг төсвөөс төлж авлага үүсгэсэн, буруутай албан тушаалтнаар 3.3 сая төгрөгийг төлбөрийг барагдуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайланд онд нэмэлт санхүүжилтээр төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 198.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 252.5 сая төгрөг, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 726.4 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн 14.5 сая төгрөгийн, нийт 1,192.1 сая төгрөгийн орлоготой авч, 1,148.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 43.8 сая төгрөгөөс улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Тайлант хугацаанд татаас санхүүжилтийн авлагаар 43.8 сая төгрөгийг бүртгэж, Сангийн яамны төрийн сантай тооцоо нийлж актаар баталгаажуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

СХЗГ-ын 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд СХЗГ-ын даргын 2025 оны А/235 дугаар тушаалаар өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Шадар сайдын багцад тусгагдсан 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Стандарт, хэмжил зүйн салбарын лабораториудын их засвар (*Улаанбаатар*) 3,046.0 сая төгрөгөөр, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа, лабораторийн их засвар (*Улаанбаатар, Хан-Уул дүүрэг*) 1,553.6 сая төгрөгөөр, Стандарт, хэмжил зүйн салбарын хэмжил зүйн эталон болон бусад тоног төхөөрөмж (*Улсын хэмжээнд*) худалдан авах төлөвлөгөөг 19 багцын хүрээнд 6,800.0 сая төгрөгөөр тус тус баталж Төрийн худалдан авах ажиллагааны газарт эрх шилжүүлэн зохион байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт: СХЗГ-ын харьяа байгууллагуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 10.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- СХЗГ-ын даргын 2025 оны А/93 дугаар тушаалаар "Стандарт, хэмжил зүйн газрын албан хаагчдын бие бялдрын хөгжлийг дэмжих арга хэмжээ"-г зохион байгуулж байгууллагын төсвөөс 9.7 сая төгрөгийг зарцуулсан;
- Хэнтий аймаг дахь СХЗХ нь албан хаагчдыг хувцаслалтаар жигдрүүлж 0.8 сая төгрөгөөр нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас цамц худалдан авсан;
- Говь-Алтай аймаг дахь СХЗХ нь 3.1 сая төгрөгийн компьютер, принтер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу СХЗГ-ын 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

СХЗГ-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өр төлбөр, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитор С.Болортуяа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, дараагийн үе шатны хяналтуудыг газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

СХЗГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/301 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 36,188.5 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 361.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага ямар нэгэн тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 6,077.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 494.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлагыг хүргүүлж, 5,583.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн. Үүнээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хяналтыг сайжруулах, шийдвэрийг хэрэгжүүлэх, зөрчлийг багасгах талаар 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих зарим мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроосон, зөрчлийг давтан гаргасан, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй 333.2 сая төгрөг; /СХЗГ 184.1 сая төгрөг, Өмнөговь аймгийн СХЗХ 97.7 сая төгрөг, ХАБҮЛЛ 33.6 сая төгрөг, Дархан-Уул аймгийн СХЗХ 17.8 сая төгрөг /

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа 23 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 117 алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 1,587.9 сая төгрөгийн 56 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 6,077.7 сая төгрөгийн 15 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;" 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;" 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг 15-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төвлөрүүлэн захирагчийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудад 29.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 3,328.0 сая төгрөгийн 32 албан шаардлага, 19,487.3 сая төгрөгийн 42 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---------------|------------------------|----------|---------|----------|-------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 12 | 29,472.9 | 12 | 29,472.9 | 100.0 |

| | | | | | |
|-----------------|-----------|---------------------|-----------|---------------------|-------------|
| Албан шаардлага | 33 | 3,343,046.0 | 32 | 3,328,046.0 | 99.5 |
| Зөвлөмж | 42 | 19,487,366.6 | 42 | 19,487,366.6 | 100.0 |
| Дүн | 87 | 22,859,885.5 | 86 | 22,844,885.5 | 99.8 |

Өмнөх оны аудитаар хүргүүлсэн шийдвэрээс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 15.0 сая төгрөгийн үнэ бүхий автомашины хохирлыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. Энэ асуудлаар Стандарт, хэмжил зүйн газар нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2025 оны 01 дүгээр сарын 31-ны 01/161 дугаар албан бичгээр нэхэмжлэл гаргасан байна. Нэхэмжлэлийн дагуу 2025 оны 9, 10 дугаар саруудад шүүх хурал зарлагдсан боловч байгууллагын төлөөлөл болсон албан хаагч ээлжийн амралттай байсан, шүүх бүрэлдэхүүн цуцлагдаж зэрэг шалтгаанаар хурал хойшлогдож, 2026 онд шүүх хурал дахин товлогдсон байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар орлогын төлөвлөлт, үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

СХЗГ-ын төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 48,547.0 сая төгрөгийн 59 алдаа¹ илэрснээс 32,663.9 сая төгрөгийн 54 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 15,883.1 сая төгрөгийн залруулагдаагүй 5 алдааг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 3,356.4 сая төгрөгийн зөрчил илэрч, 32.9 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 1,473.0 сая төгрөгийн зөрчилд 28 албан шаардлага хүргүүлэн, 1,850.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 22 зөвлөмжийг өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 19,239.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 18,877.7 сая төгрөгөөр их тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өглөө.

5.1. Стандарт хэмжил зүйн газрын харьяа байгууллагууд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд СХЗГ-ын харьяа 23 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 12 байгууллагад дүгнэлт гаргаж, 11 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 12 байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" 8, "Хязгаарлалттай" 4 (СХЗГ, ХАБҮЛЛ, Төв аймаг дахь СХЗХ, Увс аймаг дахь СХЗХ) дүгнэлт өгсөн байна.

СХЗГ-ын харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 43,836.6 сая төгрөгийн 51 алдаа илэрснээс 27,953.5 сая төгрөгийн 46 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 15,883.1 сая төгрөгийн залруулагдаагүй 5 алдааг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 1,587.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 33.0 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоон, 1,134.1 сая төгрөгийн зөрчилд 27 албан шаардлага, 420.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 20 зөвлөмж өгсөн.

5.2. Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 4,710.4 сая төгрөгийн 8 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 1,768.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 339.0 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1,429.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг өгсөн.

5.2.1. Албан шаардлага

1. Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-т улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжсэн 339.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Стандарт хэмжил зүйн газрын өргөтгөлийн барилгын зураг боловсруулах" зураг төслийг 2025 оны 08 дугаар сарын 08-ний өдөр Стандарт хэмжил зүйн газар хүлээн авсан боловч хөрөнгөнд бүртгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.5.1-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ"; 5.5.2-д "Энэ журмын 5.5.1-д заасан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх чиг үүргийг захиалагчийн өмчийн асуудал хариуцсан нэгж (ажилтан) хэрэгжүүлэх бөгөөд өмчид бүртгүүлэхийг тодорхойлох урьдчилсан маягыг бөглөн цахим системээр гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтэд хамт ирүүлж, цахим системийн өмчийн санд мэдээллийн санг бүрдүүлнэ"; 5.5.3-д "Өмчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлсон шийдвэрийн дагуу төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн системд өмчийн бүртгэл хийгдсэнээр цахим систем дэх урьдчилсан бүртгэлийн мэдээлэл баталгаажиж өмчийн мэдээллийн санд бүртгэгдэнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлсэн ТЭЗҮ-г данс бүртгэлд тусгах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөрийн дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт 1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын өглөг дансны үлдэгдэл өмнөх оноос 1,386.2 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зохистой удирдаж, өглөг үүсгэхгүй ажиллаж, бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт 2. СХЗГ нь биет бус хөрөнгөд бүртгэлтэй газар эзэмших эрхэд 43.3 сая төгрөгийн элэгдэл бодож өртгийг нь бууруулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй "газар эзэмших эрх"-д элэгдэл тооцож үнэлгээг бууруулсан зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Албан шаардлага | |
|----------------------------------|------------|---------------------|-----------------------------------|-----------------|--------------------------|---------------------|------------|---------------------|--------------|---------------------|-----------------|---------------------|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Стандарт, хэмжил зүйн газрын ТТЗ | 8 | 4,710,439.5 | - | - | 8 | 4,710,439.5 | 8 | 4,710,439.5 | | | | |
| Стандарт, хэмжил зүйн газар ТШЗ | 12 | 26,045,039.4 | - | - | 11 | 23,181,191.2 | 11 | 23,181,191.2 | 1 | 2,863,848.2 | 1 | 2,863,848.2 |
| ХАБҮЛЛ | 11 | 16,460,217.6 | - | - | 7 | 3,440,943.6 | 7 | 3,440,943.6 | 4 | 13,019,274.0 | 4 | 13,019,274.0 |
| Архангай аймгийн СХЗХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Баян-Өлгий аймгийн СХЗХ | 1 | 5,227.6 | 1 | 5,227.6 | - | - | 1 | 5,227.6 | - | - | - | - |
| Баянхонгор аймгийн СХЗХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Булган аймгийн СХЗХ | 1 | 289.2 | | | 1 | 289.2 | 1 | 289.2 | - | - | - | - |
| Говь-Алтай аймгийн СХЗХ | 4 | 48,865.9 | 2 | 28,059.5 | 2 | 20,806.4 | 4 | 48,865.9 | - | - | - | - |
| Говьсүмбэр аймгийн СХЗХ | 4 | 31,558.5 | 1 | 460.7 | 3 | 31,097.8 | 4 | 31,558.5 | - | - | - | - |
| Дархан-Уул аймгийн СХЗХ | 1 | 157,251.6 | - | - | 1 | 157,251.6 | 1 | 157,251.6 | - | - | - | - |
| Дорноговь аймгийн СХЗХ | 3 | 50,150.5 | - | - | 3 | 50,150.5 | 3 | 50,150.5 | - | - | - | - |
| Дорнод аймгийн СХЗХ | 1 | 1,681.6 | - | - | 1 | 1,681.6 | 1 | 1,681.6 | - | - | - | - |
| Дундговь аймгийн СХЗХ | 3 | 87,804.9 | - | - | 3 | 87,804.9 | 3 | 87,804.9 | - | - | - | - |
| Завхан аймгийн СХЗХ | 0 | - | - | - | | | | | - | - | - | - |
| Орхон аймгийн СХЗХ | 0 | - | - | - | | | | | - | - | - | - |
| Өвөрхангай аймгийн СХЗХ | 1 | 100.0 | - | - | 1 | 100.0 | 1 | 100.0 | - | - | - | - |
| Өмнөговь аймгийн СХЗХ | 1 | 846,523.4 | - | - | 1 | 846,523.4 | 1 | 846,523.4 | - | - | - | - |
| Сүхбаатар аймгийн СХЗХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Сэлэнгэ аймгийн СХЗХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Төв аймгийн СХЗХ | 3 | 2,863.2 | - | - | 3 | 2,863.2 | 3 | 2,863.2 | - | - | - | - |
| Увс аймгийн СХЗХ | 2 | 86,445.8 | - | - | 2 | 86,445.8 | 2 | 86,445.8 | - | - | - | - |
| Ховд аймгийн СХЗХ | 1 | 10,997.7 | - | - | 1 | 10,997.7 | 1 | 10,997.7 | - | - | - | - |
| Хөвсгөл аймгийн СХЗХ | 2 | 1,627.7 | - | - | 2 | 1,627.7 | 2 | 1,627.7 | - | - | - | - |
| Хэнтий аймгийн СХЗХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | 59 | 48,547,084.1 | 4 | 33,747.8 | 50 | 32,630,214.1 | 54 | 32,663,961.9 | 5 | 15,883,122.2 | 5 | 15,883,122.2 |

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|--|-------------|--------------------|---------------|-----------------|-----------------|--------------------|-----------|--------------------|--------------------------------------|---------------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| Стандарт, хэмжил зүйн газрын ТТЗ | 3 | 1,768,563.0 | | | 1 | 339,000.0 | 2 | 1,429,563.0 | - | - |
| Стандарт, хэмжил зүйн газар ТШЗ | 5 | 652,700.6 | | | 5 | 652,700.6 | | | - | - |
| Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори | 6 | 654,037.9 | 1 | 9,398.7 | 4 | 351,712.0 | 1 | 292,927.2 | - | - |
| Архангай аймгийн СХЗХ | 1 | 1,785.6 | 1 | 1,785.6 | - | - | - | - | - | - |
| Баян-Өлгий аймгийн СХЗХ | 0 | - | - | - | - | - | - | - | - | - |
| Баянхонгор аймгийн СХЗХ | 2 | 20,968.0 | - | - | 2 | 20,968.0 | - | - | - | - |
| Булган аймгийн СХЗХ | 1 | 7,000.0 | - | - | | | 1 | 7,000.0 | - | - |
| Говь-Алтай аймгийн СХЗХ | 3 | 7,905.4 | - | - | 1 | 4,810.4 | 2 | 3,095.0 | - | - |
| Говьсүмбэр аймгийн СХЗХ | 2 | 6,788.4 | - | - | 1 | 6,788.4 | 1 | - | - | - |
| Дархан-Уул аймгийн СХЗХ | 2 | 61.6 | - | - | 1 | - | 1 | 61.6 | - | - |
| Дорноговь аймгийн СХЗХ | 3 | 4,308.2 | 1 | 675.8 | 2 | 3,632.4 | 0 | - | - | - |
| Дорнод аймгийн СХЗХ | 4 | 9,861.9 | 1 | 7,800.0 | 1 | - | 2 | 2,061.9 | - | - |
| Дундговь аймгийн СХЗХ | 3 | 23,687.2 | | | 1 | 9,800.0 | 2 | 13,887.2 | - | - |
| Завхан аймгийн СХЗХ | 2 | 12,178.0 | | | 2 | 12,178.0 | - | - | - | - |
| Орхон аймгийн СХЗХ | 3 | 14,093.5 | 1 | 4,185.9 | 2 | 9,907.6 | - | - | - | - |
| Өвөрхангай аймгийн СХЗХ | 0 | - | - | - | - | - | - | - | - | - |
| Өмнөговь аймгийн СХЗХ | 2 | 14,669.1 | - | - | 1 | 7,000.0 | 1 | 7,669.1 | - | - |
| Сүхбаатар аймгийн СХЗХ | 1 | 10,360.0 | - | - | 1 | 10,360.0 | - | - | - | - |
| Сэлэнгэ аймгийн СХЗХ | 0 | - | - | - | 0 | - | - | - | - | - |
| Төв аймгийн СХЗХ | 5 | 32,707.2 | 1 | 969.0 | 1 | 10,500.0 | 3 | 21,238.2 | - | - |
| Увс аймгийн СХЗХ | 2 | 57,987.4 | - | - | - | - | 2 | 57,987.4 | - | - |
| Ховд аймгийн СХЗХ | 2 | 10,000.0 | - | - | - | - | 2 | 10,000.0 | - | - |
| Хөвсгөл аймгийн СХЗХ | 3 | 35,089.1 | 1 | 7,000.0 | 1 | 23,207.5 | 1 | 4,881.6 | - | - |
| Хэнтий аймгийн СХЗХ | 4 | 11,682.6 | 2 | 1,182.6 | 1 | 10,500.0 | 1 | - | - | - |
| Дүн | 59 | 3,356,434.7 | 9 | 32,997.6 | 28 | 1,473,064.9 | 22 | 1,850,372.2 | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|--------------------|---------------|----------|-----------------|------------------|----------|--------------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Стандарт, хэмжил зүйн газар ТШЗ | 1 | 184,082.5 | - | - | 1 | 184,082.5 | - | - |
| Дархан-Уул аймгийн СХЗХ | 1 | 17,848.9 | - | - | 1 | 17,848.9 | - | - |
| Дундговь аймгийн СХЗХ | 1 | 33,565.3 | - | - | - | - | 1 | 33,565.3 |
| Өмнөговь аймгийн СХЗХ | 1 | 97,718.4 | - | - | 1 | 97,718.4 | - | - |
| Дүн | 8 | 333,215.1 | - | - | 5 | 299,649.8 | 3 | 33,565.3 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Стандарт хэмжил зүйн газрын ТТЗ | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| Стандарт, хэмжил зүйн газар ТШЗ | 4 | 5,621,898.9 | - | - | 1 | 71,751.0 | 3 | 5,550,147.9 |
| Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори | 3 | 115,764.0 | - | - | 2 | 115,764.0 | 1 | - |
| Говь сүмбэр аймгийн СХЗХ | 1 | 6,860.0 | - | - | 1 | 6,860.0 | - | - |
| Дүн | 8 | 5,744,522.9 | - | - | 5 | 194,375.0 | 4 | 5,550,147.9 |
| Нийт дүн | 17 | 6,077,738.0 | - | - | 10 | 494,024.8 | 7 | 5,583,713.2 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1091/АД171320

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА - СТА - ТТЗ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн улсын төсвийн үйлдвэрийн газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжсэн 339,000,000.00 (гурван зуун гучин есөн сая) төгрөгийн төсөвт өртөгтэй "Стандарт хэмжил зүйн газрын өргөтгөлийн барилгын зураг боловсруулах" /улсын хэмжээнд/ техник эдийн засгийн үндэслэлийг Стандарт хэмжил зүйн газар 2025 оны 08 дугаар сарын 08-ний өдөр хүлээн авсан боловч хөрөнгөнд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.5.1-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ;" 5.5.2-т "Энэ журмын 5.5.1-д заасан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх чиг үүргийг захиалагчийн өмчийн асуудал хариуцсан нэгж (ажилтан) хэрэгжүүлэх бөгөөд өмчид бүртгүүлэхийг тодорхойлох урьдчилсан маягтыг бөглөн цахим системээр гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтэд хамт ирүүлж, цахим системийн өмчийн санд мэдээллийн санг бүрдүүлнэ;" 5.5.3-т "Өмчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлсон шийдвэрийн дагуу төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн системд өмчийн бүртгэл хийгдсэнээр цахим систем дэх урьдчилсан бүртгэлийн мэдээлэл баталгаажиж өмчийн мэдээллийн санд бүртгэгдэнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264730

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-20.Docx

1526181451

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлсэн техник эзийн засгийн үндэслэлийг хөрөнгөндөө бүртгэж аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга (С.Батбаатар), нягтлан бодогч (Н.Даваадэмбэрэл) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
С.БОЛОРТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1092/АД 171320

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА - СТА - ТТЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа 23 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 117 алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 1,587,871,700.00 (нэг тэрбум таван зуун наян долоон сая найман зуун далан нэгэн мянга долоон зуун) төгрөгийн 56 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 6,077,738,000.00 (зургаан тэрбум далан долоон сая долоон зуун гучин найман мянган) төгрөгийн 15 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг 15-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга (С.Батбаатар), нягтлан бодогч (Н.Даваадэмбэрэл) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
С.БОЛОРТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264730

9056109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-20.Docx

1526181453